

ОРОН ТООНЫ БУС ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ

Материал хүлээн авах хугацаа: 2023 оны 04 сарын 20-ны өдрөөс 2023 оны 05 сарын 20-ны өдөр

ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Шинжээч нь төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хяналт, шалгалт хийх нийтлэг үндэслэл, журмыг удирдлага болгон дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

1. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн шинээр байгуулах эрүүл мэндийн байгууллагын төсөл, бүрдүүлсэн баримт бичигтэй танилцаж, санал гаргах
2. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байранд хяналт, үнэлгээ хийж дүгнэлтийг үнэн зөв гаргах;
3. Ажлын байранд тавигдах улсын стандартын шаардлага, шалгуурыг хангахтай холбоотой мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тусгай зөвшөөрөл хүсэгчээс шаардлагатай мэдээллийг гаргуулан авах, баримтжуулах;
4. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн шаардлагын хэрэгжилтэд явцын хяналтад оролцох,
5. Тусгай зөвшөөрлийн шаардлагын талаар холбогдох хууль эрх зүйн баримт бичиг, олон улсын туршлага мэдээлэлтэй танилцаж, МЭДЛЭГ чадвараа дээшлүүлэх;
6. Дүгнэлтийг комиссын хуралд танилцуулах;

ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Мэргэжлийн болон эрдмийн зэрэг цолтой
2. Холбогдох мэргэжлээрээ 10-с доошгүй жил ажиллаж мэргэшсэн, байгууллагын удирдлага, зохион байгуулалтаар ажлын дадлага туршлагатай
3. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах чадвартай
4. Тусгай зөвшөөрлийн шаардлагын талаар мэдлэгтэй
5. Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчил байхгүй
6. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

1. Шинжээчээр ажиллахыг хүссэн өргөдөл
2. Төрийн албан хаагчийн анкет (1-р маягт)
3. Иргэний үнэмлэхийн хуулбар
4. Мэргэжлийн диплом, зэргийн үнэмлэхийн хуулбар
5. Ажиллаж буй байгууллагын тодорхойлолт
6. Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилд холбогдоогүй талаарх ажиллаж буй байгууллагын тодорхойлолт

